



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/135

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тохиолдуулан эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн, хамт олноо манлайлан, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй хавсралтанд дурдсан алба хаагчдыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 660,000 төгрөг (зургаан зуун жаран мянган)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 660,000 төгрөг (зургаан зуун жаран мянган)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



8400 01 0754 D/Zah-A/135-Bo

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 14-ний өдрийн
А/135 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙН
БАЯРААР ШАГНУУЛАХ АЛБА ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Б.Баатархүү	Онцгой байдлын газар	Аврагч, гал сөнөөгч
2	А.Жавзандулам	Онцгой байдлын газар	Аврагч, тэсэлгээчин
3	Д.Цэвээнсүрэн	Онцгой байдлын газар	Жолооч
4	Н.Амарсайхан	Онцгой байдлын газар	Аврагч
5	Б.Баттулга	Цагдаагийн газар	Саатуулах байрны эмч
6	Ю.Баатар	Цагдаагийн газар	Цагдаа зохицуулагч
7	Б.Төмөрхүү	Цагдаагийн газар	Харуулын дарга
8	Т.Өсөхболд	Прокурорын газар	Хяналтын прокурор
9	С.Ганбаатар	Зэвсэгт хүчний 123-р анги	Хөгжмийн салааны удирдаач
10	Б.Энхтайван	Зэвсэгт хүчний 123-р анги	Артиллерийн тагнуулын дарга
11	Б.Бадамцэцэг	Зэвсэгт хүчний 123-р анги	Радио холбооны техникч
12	Ч.Ганхуяг	Зэвсэгт хүчний 123-р анги	Салааны ахлагч, тасгийн дарга
13	Т.Отгондалай	Зэвсэгт хүчний 123-р анги	Цайны газрын эрхлэгч, тогооч
14	Б.Баянмөнх	Зэвсэгт хүчний 123-р анги	Цахилгаанчин
15	Б.Баянмөнх	Гадаадын иргэн харьяатын газар	Жолооч
16	Т.Наранцэцэг	Шүүхийн шинжилгээний алба	Шинжээч
17	Х.Нямцоож	Шүүхийн шинжилгээний алба	Шинжээч
18	Д.Баярсайхан	Тагнуулын газар	Мэргэжилтэн
19	Б.Наранбаатар	Хилийн 0130 анги	Хилийн албаны тасгийн ахлах
20	Д.Бүрэнбаатар	Хилийн 0130 анги	Уурын зуухны механик
21	О.Гансүх	Хилийн 0130 анги	Уурын уухны механик
22	Д.Галамхан	Хилийн 0130 анги	Санхүүгийн тасгийн дарга

-оОо-